

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЙД, ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД, САНХҮҮ, ЭДИЙН
ЗАСГИЙН САЙД, ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ХАМТАРСАН ТУШААЛ

2004 оны 08 дугаар
сарын 02-ний өдөр

Дугаар 74 / 154 / 170 / 175 Улаанбаатар хот

Журам батлах тухай

Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 5.1-д заасныг үндэслэн ТУШААХ нь:

- “Хүнсний болон техникийн зориулалтаар ашиглах спиртийн хуваарилалт, олголт, зарцуулалт, түүнд хяналт тавих журам”-ыг хавсралтаар баталсугай.
- Энэ журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн, Хууль зүй, дотоод хэргийн, Санхүү, эдийн засгийн, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга нар, Улсын мэргэжлийн хяналтын газрын дарга, Үндэсний татварын ерөнхий газрын дарга, Цагдаагийн ерөнхий газрын дарга, Гаалийн ерөнхий газрын дарга нарт тус тус үүрэг болгосугай.
- Энэ журам батлагдсантай холбогдуулан “Журам батлах тухай” Сангийн сайд, Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан 1998 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 356, А/191, А/353 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН
САЙД

Д. НАСАНЖАРГАЛ

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН
САЙД

Ч. УЛААН

Хуулбар унэн
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ
УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГА


ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД

Н. НЯМДОРЖ

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

П. НЯМДАВАА

Д. ЖАНЦАНХОРОЛ



Хүнс, хөдөө аж ахуйн, Хууль зүй, дотоод хэргийн, Санхүү, эдийн засгийн, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2004 оны 74/139/10/1939 тушаалын хавсралт

ХҮНСНИЙ БОЛОН ТЕХНИКИЙН ЗОРИУЛАЛТААР АШИГЛАХ СПИРТИЙН ХУВААРИЛАЛТ, ОЛГОЛТ, ЗАРЦУУЛАЛТ, ТҮҮНД ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

Холбогдох хууль, тогтоомжийн заалтыг үндэслэн хүнсний болон техникийн зориулалттай спиртийг хуваарилах, олгох, зарцуулах, түүнд хяналт тавихад энэхүү журмыг мөрдөнө.

Нэг. Спирт хуваарилах

1.1. Аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар тухайн жилд хэрэглэх хүнсний болон техникийн зориулалтаар ашиглах спиртийн захиалгыг холбогдох татварын албаны тодорхойллыг үндэслэн зохих журмын дагуу үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага тус бүрээр гаргаж /1 дүгээр хавсралт маягтын дагуу/, жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны дотор дурдсан байгууллагуудад хүргүүлнэ. Үүнд:

- 1.1.1. тухайн нутаг дэвсгэрт ажиллаж байгаа согтууруулах ундааны үйлдвэрийн хэрэгцээт спиртийн захиалгыг Хүнс, хөдөө аж ахуйн яаманд
- 1.1.2. хүн эмнэлэг, эмийн үйлдвэрийн хэрэгцээт спиртийн захиалгыг Эрүүл мэндийн яаманд
- 1.1.3. мал эмнэлэг, мал үржлийн ажил, малын эмийн үйлдвэрийн хэрэгцээт спиртийн захиалгыг Улсын мал эмнэлэг, үржлийн газарт

1.2. Захиалгад дараахь бичиг баримтыг хавсаргана. Үүнд:

- 1.2.1. спиртийн татан авалт, зарцуулалт, онцгой албан татвар төлөлтийн тайлан
- 1.2.2. тухайн аж ахуйн нэгжийн харьяалагдах татварын албаны тодорхойлолт

1.3. ЭМЯ, Улсын мал эмнэлэг, үржлийн газар холбогдох аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газраас ирүүлсэн тухайн жилийн хэрэгцээт спиртийн захиалгыг хянаж, нэгтгэн жил бүрийн 12 дугаар сарын 01-ний дотор Хүнс, хөдөө аж ахуйн яаманд хүргүүлнэ.

1.4. Тухайн жилд үйлдвэрлэх спиртийн хэмжээнд үндэслэн 1.1.1, 1.3-т дурдсан захиалга, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлт, өмнөх оны спиртийн хувиарлалт, зарцуулалт зэргийг харгалзан дор дурьдсан зориулалтаар ангилан, дараа онд олгох спиртийн хэмжээг тогтоосон хуваарийг Хүнс, хөдөө аж ахуйн яамны Төрийн нарийн бичгийн дарга баталж, дараахь байгууллагуудад хүргүүлнэ. Үүнд:

- 1.4.1. хүн эмнэлэг, эмийн үйлдвэрлэлд зориулан олгох спиртийн хуваарийг Эрүүл мэндийн яаманд
- 1.4.2. мал эмнэлэг, мал үржлийн ажил, малын эмийн үйлдвэрлэлд зориулан олгох спиртийн хуваарийг Улсын мал эмнэлэг, үржлийн газарт
- 1.4.3. согтууруулах ундааны үйлдвэрлэлд зориулан олгох спиртийн хуваарийг Татварын ерөнхий газарт
- 1.4.4. Дээрх байгууллагуудад хүргүүлсэн спиртийн хуваарийг спиртийн үйлдвэрүүдэд

1.5. Хүнс, хөдөө аж ахуйн яамны Төрийн нарийн бичгийн даргын баталсан хуваарьт заасан спиртийн хэмжээг харгалзан энэ журмын 1.4.1-1.4.3-т заасан байгууллага нь тус тусын харьяалагдах аж ахуйн нэгж, байгууллага бүрт оногдох спиртийн хэмжээг тогтоосон хуваарийг 12 дугаар сарын 25-ны дотор багтаан батална.

1.6. Тухайн жилд олгох спиртийн хуваарийг баталснаас хойш байгуулагдсан, хуваарьт спиртийн үйлдвэрээс спирт авах боломжгүй, түүнчлэн спиртийн хэрэгцээ бий болсон /спирт экспортлох, тоног төхөөрөмж, багаж хэрэгслэл ариутгах г.м/ аж ахуйн нэгж, байгууллага шаардлагатай спиртийн захиалгыг Хүнс, хөдөө аж ахуйн яаманд гаргана.

• 1.7. Хүнс, хөдөө аж ахуйн яам энэ журмын 1.6-д заасны дагуу хүсэлт гаргасан аж ахуйн нэгж, байгууллагад спирт үйлдвэрлэгч аж ахуйн нэгжээс болон холбогдох хууль тогтоомжид заасан журмаар хураасан спиртийг олгуулахаар нэмэлт хуваарь гаргаж болно.

1.8. "Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль"-ийн 13.1 дэх хэсэгт заасны дагуу эрх бүхий байгууллагын шийдвэрээр хураагдсан спиртийн хэмжээг тухай бүр ХХАЯЯ-нд мэдэгдэх бөгөөд тус яам шинжилгээний дүн, дүгнэлт, хэрэглэгч байгууллагын захиалгыг үндэслэн уг спиртийг хуваарилна.

1.9. Энэ журмын 1.2-т заасан баримт бичгийг бүрдүүлээгүй, ногдуулсан татварыг бүрэн төлөөгүй, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг зөрчсөн тохиолдолд уг зөрчлийг арилгах хүртэл спирт хуваарилахыг хойшлуулна.

Хоёр. Спирт олгох

2.1. Энэ журмын 1.5-д заасан хуваарийн дагуу спирт олгох ажлыг спирт үйлдвэрлэгч аж ахуйн нэгж, хураагдсан спиртийг олгох ажлыг уг спиртийг хураан авсан байгууллага тус тус хариуцана.

2.2. Спирт олгогч нь дараах баримт бичгийг үндэслэн аж ахуйн нэгж, байгууллагад хуваарьт спиртийг олгоно. Үүнд:

2.2.1. Хүнс, хөдөө аж ахуйн яам, Эрүүл мэндийн яам, Улсын мал эмнэлэг, үргжлийн газраас аж ахуйн нэгж, байгууллагад олгосон спиртийн хуваарь;

2.2.2. Худалдан авагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн иргэний үнэмлэх, Зх4 хэмжээ, үзүүлэх зураг бүхий баталгаатай хоёр хувь итгэмжлэл /нэг хувийг спирт олгогчид үлдээнэ/, гарын үсгийн баталгаажсан загвар;

2.2.3. Согтууруулах ундаа үйлдвэрлэдэг аж ахуйн нэгжид өмнө авсан спирт; үйлдвэрлэсэн согтууруулах ундаанд ногдуулсан онцгой албан татварыг төлсөн тухай харилцаг татварын албаны тодорхойполт;

2.2.4. Аж ахуйн нэгж нь улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

2.2.5. Согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээний натриотаар гэрчлүүлсэн хуулбар; / гэрчилгээний сунгалтын хугацааг шалгана/

2.2.6. Спиртийн үнийг төлсөн тухай санхүүгийн баримт

• 2.3. Энэ журмын 2.2-т заасны дагуу аж ахуйн нэгж, байгууллагад спирт олгоходо спирт олгогч зарлагын мэдүүлэг бичих бөгөөд мэдүүлэгт дараах үзүүлэлтийг заавал тусгасан байна.

2.3.1. Спирт худалдан авагч аж ахуйн нэгж, байгууллагын нэр, хаяг, улсын бүртгэлийн дугаар;

2.3.2. Согтууруулах ундааны үйлдвэрлэл эрхэлдэг бол тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаар

2.3.3. Спиртийн тоо хэмжээ, үнэ;

2.3.4. Спирт тээвэрлэгч автомашины дугаар, жолоочийн овог нэр, жолооны үнэмлэхийн дугаар;

2.3.5. Спиртийг хүлээн авсан итгэмжлэгдсэн төлөөлөгчийн овог нэр, албан тушаал, оршин суух хаяг, иргэний үнэмлэхийн болон регистрийн дугаар, гарын үсэг;

2.3.6. Спирт олгосон он, сар, өдөр.

2.4. Зарлагын мэдүүлэгт итгэмжлэл авсан сорилтын лабораторийн спиртийн шинжилгээний дүн, дүгнэлтийг дагалдуулна.

2.5. Спиртийг зориулалтаас өөр зүйлд ашиглах, худалдан борлуулахыг хориглоно.

Гурав. Татварын байгууллагын тодорхойлолт

3.1. Согтууруулах ундаа үйлдвэрлэгч аж ахуйн нэгж, байгууллагын харилцдаг татварын алба дараах бичиг баримтыг үндэслэн, аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газарт спиртийн захиалга, хуваарьт оруулах тухай, спирт олгогч аж ахуйн нэгж, байгууллагад хуваарьт спиртийг олгох тухай тодорхойлолтыг тус тус гаргана.

3.1.1. тухайн аж ахуйн нэгж, байгууллага нь худалдан авсан спиртийг нягтлан бодох бүртгэл, тайлан тэнцэл, татварын тайланд тусгасан эсэх;

3.1.2. үйлдвэрлэсэн согтууруулах ундааны борлуулалтад ногдуулсан онцгой албан татвар, түүний төлөлт;

3.1.3. татварын ертэй болон албан татварын тайланг хугацаанд нь өгсөн эсэх;

3.1.4. өмнөх онд хуваарилалтын дагуу спирт авсан эсэх;

3.2. Энэ журмын 3.1-д заасан тодорхойлолтыг аймагт тухайн аймгийн татварын хэлтэс, нийслэлд тухайн аж ахуйн нэгж, байгууллагын харилцдаг татварын алба олгоно. Аймаг, нийслэлийн татварын алба нь уг тодорхойлолтын хувийг Үндэсний татварын ерөнхий газар хүргүүлнэ.

3.2. Татварын алба согтууруулах ундаа үйлдвэрлэгч аж ахуйн нэгж байгууллагад сүүлийн 3 жилд хуваарилсан спирт, үүнээс татах авсан, зарцуулсан, үлдэгдэл болон үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд ногдох онцгой албан татварын ногдуулалт, төлөлтийн байдлыг үндэслэн уг аж ахуйн нэгж, байгууллагыг спиртийн захиалгад оруулах, эсэх талаарх санал, тодорхойлолтоо зохих үндэслэл, тооцоо судалгааны хамт аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газарт хүргүүлнэ.

Дөрөв. Мэдээлэл өгөх

4.1. Энэ журмын 1.5, 1.7-д заасан хуваарийг баталснаас хойш ажлын 10 хоногт багтаан Үндэсний татварын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар болон Улсын мэргэжлийн хяналтын газарт тус тус хүргүүлнэ.

4.2. Энэ журмын 4.1-д заасны дагуу Үндэсний татварын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар болон Улсын мэргэжлийн хяналтын газар нь мэдээллийг хүлээн авсанаас хойш 10 хоногийн дотор харьяа албадад хүргүүлнэ.

4.3. Спиртийн үйлдвэр, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, хил хамгаалах, гааль, татварын байгууллага болон мэргэжлийн хяналтын газар нь 1.5, 1.7-д заасан хуваарийн дагуу татварын байгууллага болон мэргэжлийн хяналтын газар нь 1.5, 1.7-д заасан хуваарийн дагуу олгосон спиртийн тухай тайланг аж ахуйн нэгж, байгууллага бүрээр сар тутам өссөн дүнгээр /2

дугаар хавсралтын маягтаар/ гаргаж, Хүнс, хөдөө аж ахуйн яам, Үндэсний татварын ерөнхий газар болон Цагдаагийн ерөнхий газарт дараа сарын 05-ны дотор хүргүүлнэ.

4.4. Үндэсний татварын ерөнхий газар нь спирт хэрэглэгч аж ахуйн нэгж, байгууллагын спиртийн хуваарилалт, олголт, татан авалт, зарцуулалт, согтууруулах ундааны үйлдвэрлэг, онцгой албан татвар төлөлтийн талаарх мэдээг сар бүр нэгтгэн гаргаж хагас, бүтэн жилийн мэдээг Санхүү, эдийн засгийн яам болон Хүнс, хөдөө аж ахуйн яаманд тус тус ирүүлнэ.

Тав. Спиртийн хуваарилалт, олголт, зарцуулалтад хяналт тавих

5.1. Мэргэжлийн хяналтын болон татварын байгууллага нь спирт хэрэглэгч аж ахуйн нэгж, байгууллагууд спиртийг хуваарийн дагуу татан авч байгаа эсэх, олгосон спиртийг зориулалтын дагуу зарцуулж буй эсэхэд хяналт тавина.

5.2. Спиртийн үйлдвэрүүдийн суурилагдсан хүчин чадал, түүний ашиглалт, үйлдвэрлэлийн хэмжээ болон гарц, бүтээгдэхүүний чанарт Мэргэжлийн хяналтын байгууллага хяналт тавьж ажиллана.

5.3. Татварын албад нь спирт хэрэглэгч аж ахуйн нэгж, байгууллага татан авсан спиртийг орлогод авсан эсэх, уг спиртээр үйлдвэрлэсэн архи бусад бүтээгдэхүүний борлуулалт ногдуулсан онцгой албан татвараа төлж буй эсэхэд хяналт тавьж ажиллана.

5.4. Энэ журмын 5.1-д заасан хяналт шалгалтыг явуулахдаа шаардлагатай бол цагдаагийн байгууллагыг оролцуулж болно.

Спиртийн хуваарилалт, олголттой холбогдуулан иргэн, байгууллагаас ирүүлсэн мэдээллийн дагуу хяналтын холбогдо байгууллага шалгалт явуулна.

214

"Хүнсний болон техникийн зориулалтаар ашиглах спиртийн хуваарилалт, олголт, зарцуулалт, түүнд хяналт тавих журам"-ын 2 дугаар хавсралт

АЖ АХҮЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГАД ОЛГОСОН СПИРТИЙН ТАЙЛАН

Спирт борлуулсан аж ахуйн нэр:
Байршил, хаяг, утасны дугаар:
Регистрийн дугаар:

Тайлангийн сар:

№	Спирт олгосон огноо	Спирт олгосон аж ахуйн нэгж, байгууллагын Орших аймаг, хотын нэр			Улсын бүртгэлийн Гэрчилгээний регистр	Олгосон спиртийн хэмжээ, эссеэн дүнгээр /литрээр/	1 литр спиртийн үнэ /төгрөгөөр/	Нийт үнэ /төгрөгөөр/
		Нэр						
1								
2								
3								
4								
5								
6								
7								
8								
9								
10								
11								
12								
13								
14								
15								
16								
17								
18								
19								
20								
21								
22								
23								
24								
25								
26								
27								
28								
29								
30								
31								
32								
33								
34								
35								
36								
37								
38								
39								
40								
41								
42								
43								
44								
45								
46								
47								
48								
49								
50								
51								
52								
53								
54								
55								
56								
57								
58								
59								
60								
61								
62								
63								
64								
65								
66								
67								
68								
69								
70								
71								
72								
73								
74								
75								
76								
77								
78								
79								
80								
81								
82								
83								
84								
85								
86								
87								
88								
89								
90								
91								
92								
93								
94								
95								
96								
97								
98								
99								
100								
101								
102								
103								
104								
105								
106								
107								
108								
109								
110								
111								
112								
113								
114								
115								
116								
117								
118								
119								
120								
121								
122								
123								
124								
125								
126								
127								
128								
129								
130								
131								
132								
133								
134								
135								
136								
137								
138								
139								
140								
141								
142								
143								
144								
145								
146								
147								
148								
149								
150								
151								
152								
153								
154								
155								
156								
157								
158								
159								
160								
161								
162								
163								
164								
165								
166								
167								
168								
169								
170								
171								
172								
173								
174								
175								
176								
177								
178								
179								
180								
181								
182								
183								
184								
185								
186								
187								
188								
189								
190								
191								
192								
193								
194								
195								
196								
197								
198								
199								
200								
201								
202								
203								
204								
205								
206								
207								
208								
209								
210								
211								
212								
213								
214								
215								
216								
217								
218								
219								
220								
221								
222								
223								
224								
225								
226								
227								
228								
229								
230								
231								
232								
233								
234								
235								
236								
237								
238								
239								
240								
241								
242								
243								
244								
245								
246								
247								
248								
249								
250								
251								
252								
253								
254								
255								
256								
257								
258								
259								
260								
261								
262								
263								
264								
265								

Тайлан гаргасан:

Захирал: / /

Ня-бо: /...../

200.. оны... сарын... өдөр

"Хүнсний болон ашиглах техникийн спиртийн зориулалтаар хувваарилалт, олголт, зарцуулалт, түүнд хяналт тавих журам"-ын 1 дүгээр хавсралт

ХҮНСНИЙ БОЛОН ТЕХНИКИЙН ЗОРИУЛАЛТААР АШИГЛАХ СПИРТИЙН ЗАХИАЛГА

Аймаг, хотын нэр:
Огноо:

Д/д	Аж ахуйн нэгж, байгууллагын нэр	Үйлдвэрийн хүчин чадал	Авах спиртийн хэмжээ /тн-оор/	Спирт олгох аж ахуйн нэгжийн нэр	Өмнөх онд хувааарийн дагуу авсан эсэх	Тайлбар
	Дүн					

Захиалгыг нэгтгэсэн: / Нэр, албан тушаал, байгууллага

Захиалгыг хянасан: / Нэр, албан тушаал, байгууллага

200 . оны . . . сарын . . . өдөр